

03 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн Онцгой комисс цаг үеийн асуудал, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан 3 удаа хуралдаж 14 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын онцгой комиссоос гаргасан уриалгыг Сүхбаатар аймгийн ард иргэд, ААНБ-ууд идэвхтэй дэмжиж, аймгийн Онцгой комисст хандив өгөх ажил зохион байгуулагдаж байна. Одоогийн байдлаар 56,6 сая төгрөг бэлнээр цугласан ба 4.0 сая төгрөгийн бараа, эд материал, 2500 гаруй амны хаалт, 9 сумаас 1100 гаруй хонь хандивласан байна

Хилийн боомтуудаар газрын тос, хүрэн нүүрс болон бусад тээвэрлэлтийг нэвтрүүлэх болсонтой холбоотойгоор Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшингээр ахлуулсан ажлын хэсэг энэ сарын 27-ны өдөр Бичигт боомтод ажиллаж шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бэлэн байдал, тулгамдаж буй асуудалтай танилцаж тодорхой үүрэг чиглэлийг өгсөн ба холбогдох мэргэжлийн байгууллагууд үүргийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: 13 сум, 27 агентлаг, төсөвт байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг нэгтгэн засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.

2019 оны ил тод байдал, хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан зорилт аймгийн засаг даргаас зг-ын гишүүн, сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт, аймгийн 2019 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайланг тус тус цахимаар болон цаасан хэлбэрээр згхэг-ын хшдаг-т хүргүүлсэн.

Мөн аймгийн 2019 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын ажлын зурагт тайлан сэтгүүлийг эмхтгэн хэвлүүлээ.

Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан улсын тэргүүний сум шалгаруулах болзол журмын хүрээнд тус аймгаас шалгаран өрсөлдөж буй Уулбаян сумын тайлан мэдээлэл дээр ажиллаж зөвлөн тусаллаа.

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба: Орон нутгийн телевизээр дамжуулан цаг үеийн мэдээ мэдээллийг 23 удаа иргэд олон нийтэд хүргэж ажиллалаа.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар цахим хуудсаар 73 мэдээллийг 130 мянган хүнд хүргэсэн. Түүнчлэн Сүхбаатарын өнгө сонины дугаарт мэдээлэл бэлтгэн нийтлүүлж байгууллага, иргэдэд түгээлээ.

Аймгийн Засаг дарга, Тамгын газраас 2019 онд хийж хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын тайланг эмхэтгэн багтаасан сэтгүүлийг хэвлүүлж, сум, байгууллага, иргэдийн хүртээл болголоо.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2020 оны 3 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 3,763.8 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 1,582,2 сая төгрөгийн орлого орж нийт 5,346,0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

Эхний 3 сарын байдлаар Улсын төсөвт 629,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 637,1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 101,2 хувиар, Орон нутгийн төсөвт 1,465,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,582,2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 108 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 1431,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 11383,6 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа.

Дэлхий нийтэд цар тахлын хэмжээнд хүрээд буй өвчний нөхцөл байдалтай холбоотойгоор орон нутагт үүсч болзошгүй эрсдэлийг тооцох, энэ нөхцөлд хэрхэн ажиллах, аймгийн төсвийн 2020 оны батлагдсан орлогын төлөвлөгөөг хэрхэн биелүүлэх зэрэг асуудлуудаар аймгийн Татварын хэлтэс, ГХБХБГ-ын удирдлага, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй асуудал, цаашид хамтран авч хэрэгжүүлэх ажлын талаар ярилцаж зөвлөлдлөө.

13 шууд захирагчийн 2019 оны төсвийн аудитлагдсан санхүүгийн тайланг шалгаж хүлээн авч дууслаа. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан шалган хүлээн авч байна.

743 аж ахуйн нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хянаж хүлээн авч 85 хувьтай нэгтгэж Сангийн яаманд хүргүүллээ.

Татварын хэлтэс: Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх нээлттэй утсыг иргэдэд зарлаж, утсаар болон e-майл хаягаар, ажлын байранд нь, хэсэгчилсэн, нэг цэгийн үйлчилгээний танхимаар дамжуулан татвар төлөгчдөд заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна.

ХХОАТ-ын тухай хуулийн заалтын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр хүсэлтээ ирүүлсэн 890 иргэний материалыг шалгаж хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна.

Орон нутгийн өмчийн газар: Аймгийн хэмжээний орон нутгийн өмчит 141 хуулийн этгээдийн 2019 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн нэгтгэлийг хийж аймгийн нэгдсэн балансыг хуулийн хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар 16 хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаагаар шийдвэрлэсэн бөгөөд 03 дугаар сарын 17-ны өдөр нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж 3 хөрөнгө дээр оролцогч оролцон аймгийн төсөвт 10,800,000 (арван сая найман зуун мянга) төгрөгийг төвлөрүүллээ.

Худалдан авах ажиллагааны хүрээнд: 2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 94 нэр төрлийн 23,699,2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн байна. Үүнд:

1. Улсын төсвөөс санхүүжилтээр 31 нэр төрлийн 11,032,3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ
2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 55 нэр төрлийн 11,342,4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ
3. Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр 7 нэр төрлийн 1,324,4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ

Дээрхи үйл ажиллагаанаас 20 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах эрхийг аймгийн Засаг даргын захирамжаар харьяа байгууллагууд руу шилжүүлсэн байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах 74 төсөл, арга хэмжээнээс 45 арга хэмжээний үнэлгээний хороо байгуулагдаж, 649,4 сая төгрөгийн өртөг бүхий 14 бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч тодорч гэрээ байгуулах зөвлөмж хүргүүллээ. 16 бараа, ажил үйлчилгээний тендер зарлагдаад байна. 1 ажлын үнэлгээ хийгдэж байна

Санхүүгийн хяналт, аудитын алба: Баяндэлгэр, Түвшинширээ сумдын төсөвт байгууллагуудын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт, дээрхи сумдын ЗДТГазар, ИТХурлын үйл ажиллагаанд дотоод аудит мөн аймгийн Ахмадын хорооны үйл ажиллагаанд дотоод аудит хийж улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага 2, улсын ахлах байцаагчийн нийт 1,093,752.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоон ажиллалаа.

Гурав. Хууль эрх зүйн салбарт:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж холбогдох албан тушаалтнуудад батлуулахаар хүргүүлсэн.

Архивын чиглэлээр: Лавлагаа 78, хуулбар 27 нийт 51 иргэдэд хөдөлмөрчдөд давхардсан тоогоор 341 гаруй хадгаламжийн нэгжээр үйлчилсэн.

Цахимд хадгаламжийн нэгж буюу 1220 хуудас баримтыг скайнер, photoshop-д оруулаад байна. нөхөн бүрдүүлэлтээр барилгын зураг төслийн 25 хадгаламжийн нэгж хүлээн авсан.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тус хэлтэс 2020 оны 03 дугаар сарын байдлаар дараах бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-93, анхны бүртгэл-20, өмчлөх эрх шилжих гэрээ-12, барьцааны гэрээ-50, бүртгэлд өөрчлөлт оруулах -4, лавлагаа хуулбар-4, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-35, нийт бичигдсэн лавлагааны тоо-3,

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо-95, өмчлөх эрх шилжих гэрээ-13, барьцааны гэрээ-48, бүртгэлд өөрчлөлт оруулах -8, лавлагаа хуулбар-82 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-45, нийт бичигдсэн лавлагааны тоо-2

Хуулийн этгээдийн бүртгэл

- 2020 оны 03 дугаар сарын байдлаар улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1176. Тухайн сард шинээр нийт ххк-3, салбар 1 бүртгэгдсэн. Татан буугдсан бүртгэл 2, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-2, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-7, хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт хийсэн-6, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон-5, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг-1, лавлагаа-4

Иргэний бүртгэл

- Иргэний бүртгэлийн тасаг нь 2020 оны 03 сарын байдлаар нийт 121 төрөлт, гэрлэлт 27, гэрлэлт цуцлалт 5, үрчлэлт 2, эцэг тогтоолт 0, овог нэр өөрчлөлт 5, нас баралт 23, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 0, үндэсний энгийн гадаад паспорт 27, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 84, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 492 тус тус бүртгэгдэж олгосон байна.

Шүүхийн шинжилгээний алба: Нийт 489 кадр гэрэл зураг авагдсан байх ба шинжилгээний 9, хэргийн газрын үзлэгийн 268, цогцосны гадна үзлэг болон задлан шинжилгээний 192, бусад ажиллагааны 20 кадр гэрэл зураг авагдсан.

Цагдаагийн газар: Улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэр, засаг даргын 2020 оны а/198 дугаар захирамжийг үндэслэн улаанбаатар хот, аймаг, сум хоорондын хөдөлгөөнийг түр хязгаарласантай холбогдуулан сүхбаатар аймгийн хэмжээнд 66 постонд 145 алба хаагч /үүнээс төрийн бусад байгууллагын 107/ -д 24 цагаар үүрэг гүйцэтгэж байна.

“Гэр бүл бол амьдрал эхэлж, хайр төгсдөггүй орчин” улсын хэмжээнд явагдаж буй “хайр өвтгөдөггүй” арга хэмжээний хүрээнд сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын “эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамт олны дунд эерэг харилцаа, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор амны хаалт 100 ширхэгийг өөрсдөө оёж, амин дэм, дархлааг дэмжих бэлдмэлийг алба хаагчдад тарааж өглөө.

Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулж буй “өнгө нэмцгээе-2020” нөлөөллийн аяны хүрээнд тээврийн цагдаагийн албанаас энэ оны 3, 4 дүгээр саруудад хариуцан зохион байгуулах “хорт зуршил- эрүүл бие” сэдэвт арга хэмжээний нээлтийг 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Аяны хүрээнд сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын хамт олноос цагдаа, дотоодын цэргийн нийт алба хаагч та бүхнийг хорт зуршлаа хаяж, спортоор хичээллэж, эрүүл байхыг уриалж ажиллалаа.

Тус цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас алба хаагчдын дунд аяны уриалга бүхий туг, “хорт зуршлын эсрэг хамтдаа тэмцье” амлалтын дэвтэр аялуулж байна.

Дөрөв. Нийгмийн бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр: 2019 онд төрийн аудитын байгууллагаас сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хийсэн дүгнэлтэд үндэслэн Баруун-Урт сумын 6 цэцэрлэгийн эрхлэгчийн ажлыг хооронд нь сэлгэн ажиллуулахаар аймгийн засаг даргын захирамж батлагдаж ажлыг хүлээлцүүлээ.

Дэлхийн банкны санхүүжилттэй хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа “орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох” төсөл хэрэгжиж эхэлж байгаатай холбогдуулан хүүхдийн ивээх сангийн ажилтныг өрөө тасалгаагаар хангаж төслийн ажлыг эхлүүлээд байна.

БСУГ-аас 03-24-ны өдөр баруун-урт суманд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн ажлын зохион байгуулалт, ариутгал халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээ, теле хичээлийн хамрагдалт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ чиглэлээр танилцаж зөвлөмж дүгнэлт өгч, 16 сургууль, 24 цэцэрлэгийн ариутгал, халдвар хамгааллын нөөцийн судалгааг авч нэгтгэсэн байна.

Харъяа байгууллагуудын цахим хуудасны үйл ажиллагаанд тандалт хийж хугацаатай үүрэг даалгавар зөвлөмж чиглүүлэгийг тогтмол өгч байна.

Аймгийн хэмжээнд ЕБС-д суралцаж байгаа болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 шатлалтай судалгааг авч дүгнэлт гарган, зөвлөмж хүргэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Гадаад хэлний 31 багш мэргэжил дээшлүүлэх онлайн сургалтад хамрагдаж, 30 цахим хичээлийг бэлтгэн суралцагчид болон иргэдийн хүртээл болгон цахим орчинд нийтлэв.

ЭШ-д бэлтгэгчдийг байнгын мэдээлэл зөвлөмжөөр ханган ажиллаж 03-р сарын 26-ны байдлаар 220 хүүхэд бүртгүүлээд байна.

Боловсролын салбарын ажилтан албан хаагчид аймгийн онцгой комист 8,2 сая төгрөгийн хандив өглөө.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Залуучууд коронавирусийн эсрэг нэгдэж байна ” гэсэн аян зарлаж цахим сүлжээнд залуучуудыг сайн дураараа амны хаалт оёхыг уриалсан уриалга бүхий постер, коронавирусээс урьдчилан сэргийлэх гар угаах, амны хаалтыг хэрхэн зүүх талаар зөвлөмж бүхий шторк , эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 15 постерыг бэлтгэж олон нийтэд хүргэлээ. Гамшиг онцгой нөхцөл байдлын үед ажиллах 15-34 насны сайн дурын ажил хийх сонирхолтой 15 залууг цахимаар бүртгэсэн.

Аймгийн ГБХЗХГ-аас 03 сарын 04-15-ныг хүртэлх хугацаанд гэр бүлийн нандин харилцааг алдаршуулах, сайхан хайраар бахархах, гэр бүлийн үнэ цэнийг нийтэд сурталчлах зорилгоор “ханилснаас илүү амраг үгүй” захидлын уралдаан зарлаж шалгаруулсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж аймгийн цагдаагийн газарт баривчлагдсан иргэдэд “зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт”-ын хөтөлбөрийн дагуу 5 иргэн сургалтад хамрууллаа. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 иргэнд өөрийнх нь хүсэлтийн дагуу сэтгэл зүйн зөвлөгөөг хүргэсэн.

ХНХЯ, БСШУЯ, ЭМЯ-ны сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан “Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хараа хяналттай байлгах, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу сумдын засаг дарга, хүүхдийн төлөө зөвлөлийн дарга нарт чиглэл, зөвлөмжийг хүргүүлж сум бүр удирдамжийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна.

“Хүүхэд – эрхэм хэрэглэгч” аяны хүрээнд “Миний гэр бүл – Аюулгүй орчин” 800 ширхэг гарын авлагыг түгээсэн.

МУ-ын ЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан “онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах болзшгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлыг хангах ажлын хүрээнд хүүхэд, гэр бүлийн эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг аймгийн хэмжээнд 7310 өрхийн 0-17 насны 16013 хүүхэд хийсэн.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, цэргийн баярын өдрийг тохиолдуулан гэр бүл, найз нөхөд болон бусад үнэлж хүндэлдэг хүмүүстээ өөрийнхөө чин сэтгэлийн талархалыг илэрхийлэх, ойлголцох тэдний нандин харилцааг бэхжүүлэх зорилгоор “тандаа баярлалаа” талархалын захидлын уралдааныг 4-8, 9-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Уг уралдаанд нийт 67 захидал ирснээс 26 захидлыг шалгарууллаа.

Охидын дуу хоолойг сонсож тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тэдгээрийг хөгжүүлэх зорилгоор 5-9 дүгээр ангийн охидыг хамруулсан “нандин” цахим групп нээн ажиллуулж байгаа бөгөөд одоогоор зорилго-зорилгыг бодит болгох, өөртөө итгэх итгэл, айсдыг даван туулах зэрэг сэдвээр сургалт мэдээллийг live –аар хийж мөн өдөр бүрийн

15-16 цагийг охид зөвхөн өөрөө өөрийгөө өөрчлөлтийн цаг болгон ажиллаж байна. Уг груп нь 200 гаруй гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Соёл урлагийн чиглэлээр: Сүхбаатар аймгийн боловсрол, соёл урлагийн салбарын ажилтан, албан хаагчдын боловсролын баримт бичгийн судалгааг бсшуся-нд хүргүүлсэн.

Соёлын төв чанартай үйлчилгээ-IV улсын уралдааны материалыг ажлын хэсгээр хэлэлцүүлж, түмэнцогт, сүхбаатар сумын соёлын төвийн материалыг журмын дагуу бүрдүүлж, соёл, урлагийн газарт удирдамжинд заагдсан хугацаанд нь хүргүүлсэн.

Хөгжимт жүжгийн театр: Олон улсын “Гэгээн муза” наадамд оролцохоор софоклын “эдип” жүжиг болон чимидийн зохиол “маш нууц” жүжгүүдийг bbs телевизээр бичүүлж, бичлэгийг явуулсан.

Сүхбаатар аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хүүхэд залуучуудын дунд хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, тэдний дархлааг дэмжих зорилгоор чөлөөт бүжгийн теле хичээлийг бэлтгэн цувралаар хүргэж байна.

Нийтийн номын сан: Номын сангийн сан хөмрөгийн данс бүртгэл, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор “номын сангийн ерөнхий данс буюу нэг бүрчилсэн бүртгэл шинэчлэх ажлын төлөвлөгөө” гаргаж, данс шинэчлэх ажлыг эхлүүлсэн.

Байгууллагын үйл ажиллагаа болон тэмдэглэлт өдрүүд, цаг үеийн байдалтай холбоотой мэдээ мэдээллийг байгууллагын цахим хаягаар тогтмол хүргэн сурталчилж байна. Үүнд: халдварт өвчний тухай эмя, уок-ын мэдээллийг аудио, зурган, сонсдог гэх мэт бүхий л хэлбэрээр мэдээлэн ажиллаж байна.

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгүүд ажиллахгүй байгаатай холбогдуулан ном уншихын ач холбогдол, ном уншиж сурах арга барилуудын талаар болон үргэлжилсэн үгийн зохиол, яруу найраг, өгүүллэг, монгол ёс заншил, өв соёл, танин мэдэхүй гэх мэт сэдвээр цахим мэдээлэл бэлтгэн оруулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн.

Угсаатны зүйн музей: Аймгийн онцгой комисст 100 ш маск болон байгууллагын ажилчид нэг өдрийн цалингаа хандивлаж 427093 /дөрвөн зуун хорин долоон мянга ерэн гурван төгрөг/ хүлээлгэж өгсөн.

Д.Доржийн нэрэмжит танхимыг олон нийтэд цахим хэлбэрээр хүргэсэн.

Биеийн тамир, сортын чиглэлээр: Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 100 ширхэг амны хаалт, хамгаалах хувцас буюу комбинзон зэрэг 500,000 /таван зуун мянга/ төгрөгийн эд зүйлсийг аймгийн онцгой комисст хандивласан.

Мөн монгол улсын шадар сайдын “коронавирусний халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам”-ыг үндэслэн спортын төв заалыг ажиглалтын 13-р байр, “б” заалыг ажиглалтын 15-р байр болгон бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах тухай хууль”, “галын аюулгүй байдлын тухай хууль”-ийн дагуу барилга байгууламжийн галын аюулгүй байдал, гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор усан спорт чийрэгжүүлэлтийн төв, бтсгазрын “б” зааланд галын аюулгүй буланг байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Улсын онцгой комисс, тхег-аас ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн засаг даргын ...-р захирамжаар коронавируст халдварын үед орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэх тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх журмыг баталж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

АНЭ-ийг эмя-ны 99.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зөөврийн рентген аппарат, аймгийн гамшгийн эрсдэлийн сангийн 50 сая, анэ-ийн 28 сая, эмг-ын 500 мянга нийт 78,5 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн нэгдсэн эмнэлэгт зөөврийн рентген аппаратуудаар хангалаа.

“Сүрьеэ өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийн хүрээнд “сүрьеэгийн эрт илрүүлэлт, сорьц тээвэрлэлтийг нэмэгдүүлэх” 1 сарын аяныг сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дунд зарлаж, “сүрьеэтэй тэмцэх үйл хэрэгт олон нийтийн анхаарлыг хандуулах, хүн бүрийн хүчин чармайлт чухал”-ыг сурталчлан таниулах зорилгоор дэлхий нийтээр сүрьеэ өвчнийг устгах амлалтаа биелүүлэх “цаг нь боллоо!” Уриа дор тэмдэглэн өнгөрүүлэх талаар цахим сургалтыг 52 эмч, эмнэлгийн ажилчдад зохион байгуулав.

В вирус гепатитын эсрэг сайн дурын вакциныг хангалттай хэмжээгээр нөөцөлж, сайн дурын дархлаажуулалтад 217 хүн, бүрэн тунгийн хамралт 70 буюу 32.2%-тай байна.

Сүхбаатар аймгийн онцгой комиссын даргаар батлуулсан удирдамжийн дагуу аймгийн засаг даргын орлогч даргаар ахлуулсан баг сумдад ажиллаж сумдын онцгой комиссын нийт 300 гаруй гишүүд, эрүүл мэндийн төвийн 300 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэнд гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийх, шадар сайдын 2017 оны 08 тоот тушаалын дагуу хариу арга хэмжээний багийг хэрхэн зохион байгуулах, багууд ямар үүрэг чиглэлтэй ажиллах, нэгдсэн болон багуудын төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ хэрхэн хийх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлтгэл бэлэн байдал, халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тусгаарлах болон ажиглалтын байрыг бэлдэх, санхүүгийн тооцоо гаргаж нөөц бүрдүүлэх, сумдын иргэдийн хөдөлгөөн, гадаадаас ирсэн иргэдийн мэдээлэл, хөл хорио тогтоосон хугацаанд иргэдээс зөрчил чирэгдэл гаргасан тохиолдолд хэрхэн ажиллах талаар сургалт, зөвлөмжийг өгч ажиллалаа.

Баруун-урт сумын здтг, мэг-тай хамтран хөгжүүлэх айл өрхийн судалгааг гарган 73 өрхийн нүхэн жорлон, муу усны нүх болон нитийн эзэмшлийн 40000 метр квадрат талбайд халдваргүйтгэл хийж, иргэдэд мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулж ажилласан.

Шадар сайдын 08 тоот тушаалын дагуу томилогдсон төлөвлөлтийн баг, хариу арга хэмжээний баг сүхбаатар тохижилт үйлчилгээ онөүг-тай хамтран хог хаягдлыг цэгт байрлах аюултай хог цэгийг цэвэрлэгээг хийж халдвартай хог хаягдлыг тээвэрлэн оруулах боломжийг бүрдүүллээ.

Covid-19 халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлын хүрээнд эмя-наас 17.2 сая төгрөгийн өртөг бүхий хамгаалах хувцас эм, хэрэгслийг нийлүүлээд байна.

Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газар нь “коронавируст халдвар (covid-19)-ын дэгдэлтийн үеийн тусламж үйлчилгээ, халдвар хамгаалал, хариу арга хэмжээ” сэдэвт сургагч багш бэлтгэх цахим сургалтыг эрүүл мэндийн газраас 4 сэдвийн дагуу зохион байгуулж нийт 13 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 126 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа.

Эмя, нэмүт, зөсүт-өөс бэлтгэсэн гаргасан зөвлөмж сургалт сурталчилгааны материалыг ашиглан 516 байгууллага, 1154 өрх, 2723 иргэн, 693 эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлсэн болон хэвтэн эмчлүүлэгчид мэдээлэл өгч олон нийтийн цахим сүлжээ (facebook)-ээр 254 төрлийн мэдээлэл байршуулж 1369 хандалт авсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2020 оны 03-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 941 иргэнээс эмэгтэй 452, бүртгэлтэй ажилгүй 720 иргэнээс, эмэгтэй 342 иргэн байна. Тайлант хугацаанд 122 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 109 иргэнийг ажилд зуучилсан байна. Аймгийн хэмжээнд бий болсон 67 шинэ ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгээд байна.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй 3 аж ахуй нэгж байгууллагын 49 гадаад/хятад/ ажилтныг монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоход байгуулгын зүгээс дэмжих саналыг олгож, хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.

Мэргэжил олгох сургалтын эрэлтийн судалгааг зохион байгуулж, 6 сумын 121 иргэнээс судалгаа аваад байна. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрийн түр ажлын байр бий болгох зорилтын хүрээнд “бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээ” “зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ” “нийтийг хамарсан ажлын” төслийг зарлаад байна.

“ажлын байрыг дэмжих хөтөлбөр” “хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр” “ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох төслүүдийг цахимаар зарласан ба одоогоор 4 төсөл хүлээн аваад байна.

Аймгийн засаг даргын 2020 оны а/237 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд хэбээн сарын аян зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр гарч байгаа тоон мэдээллийг нэгтгэн 2013-2019 оны мэдээллээр судалгаа гаргасан ба хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлт 62 иргэний 10,062.0 мянган төгрөгийн

санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн авлагыг программд оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нийгмийн халамжийн талаар: Нийгмийн халамжийн санд 2020 онд орон нутгийн төсвөөс 124,5 сая төгрөг төгрөгийг, улсын төсвөөс 9682,1 сая төгрөг нийт 9806.6 сая төгрөгийг зарцуулагдахаар батлагдсан. 2020 оны 03 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 659,0 сая.төг, тэтгэмжинд 255,0 сая.төг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 121,3 сая.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 52,0 сая.төг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөнд 85,0 сая.төг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 229,4 сая.төг, алдарт эхийн одон 678,0 сая.төг, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 7,5 сая.төг, насны хишиг 203,1 сая.төг, цалинтай эхийн тэтгэмж 160,1 сая.төг, өрх толгойлсон эцэг/эхийн тэтгэмж 50,4 сая.төг, ихэр хүүхдийн тэтгэмж 10,0 сая.төг, орон нутгаас 25,6 сая.төгрөгийн санхүүжилтийг авч арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгоод байна.

Аймгийн засаг даргын 2020 оны а/14-21 тоот захирамжаар хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхөд 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүр сонгон шалгаруулах 11 сумын тендерийг орон нутгийн өмчийн газраар зохион байгууллаа.

Монгол улсын засгийн газрын 96 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгөөр олгох болсонтой холбоотой сүхбаатар аймгийн хэмжээнд шинээр төрсөн 110 хүүхдийг мэдээллийн санд бүртгэж баяжилт хийж ажилласан. 2020 оны 03 дугаар улирлын байдлаар сүхбаатар аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичиг болон хүүхдийн мөнгөтэй холбоотой 77 өрхийн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн.

Аймгийн улаан загалмайн хороотой хамтран зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах хөтөлбөрт баруун-урт сумаас хамрагдаж байгаа 73 өрхөд коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгч, гар угаах дарааллыг танилцуулж, маск, витамин зэргийг олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын 1 удаагийн хуралд 13 хүүхэд орж, 2 хүүхэд шинээр асаргаа тогтоолгож, 10 хүүхдийн асаргаа сунгагдав.

Ххүг-н дэргэдэх ахмадын амралт, сувиллыг аймгийн засаг даргын захирамжийн дагуу коронавирусын халдвар гарсан тохиолдолд тусгаарлах байрны нөөцөд авсан болно.

Тав. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Хөрөнгө оруулалтын ажлын чиглэлээр: Нийт 5 ажлын зургийн даалгавар, 15 ажил болон барааны тендерийн техникийн тодорхойлолтыг боловсруулж худалдан авах ажиллагааны газарт хүргүүллээ.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасгийн цахилгааны засварын гэрээ хийгдэж ажлыг эхлүүлсэн. Одоогийн байдлаар нийт 5 компани аж ахуйн нэгжид гэрээ байгуулах тухай мэдэгдэл өгөөд байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр: 13 сумын сумын хөгжлийн индексийн нийт 42 үзүүлэлтийг www.lidi.nda.gov.mn цахим системд хянан баталгаажуулж дууслаа. Хэрэгжүүлэхдээ сум бүрийн оруулсан мэдээллийг аймгийн статистикийн газар, БОАЖГ, монгол банк, ЦУОШГ, БСУГ, ЭМГ-аас ирүүлсэн мэдээлэлтэй тулган мэдээллийн үнэн зөв эсэхийг хянан засч баталгаажууллаа.

“Дарьганга суманд эко аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө” боловсруулах ажлыг мерит төсөлтэй хамтран хэрэгжүүлэх хүрээнд ажлын хэсэг 3 удаа хуралдаж төлөвлөгөөний төслийг эцэслэн боловсрууллаа.

Зүүн бүсийн зөвлөлийн 2020 оны ажлын төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг нэгтгэн хүргүүллээ.

Барилга, хот байгуулалт, газрын харилцаа: засгийн газрын 317 дугаар тогтоолын дагуу хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан “Саруул хотхон”-ы орон сууцны барилгад аймгийн засаг даргын а/209 дүгээр захирамжийн дагуу 21 хүний бүрэлдэхүүнтэй улсын комиссыг зохион байгуулан ажиллалаа.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2020-2021 онд баруун-урт суманд баригдах 3000 м³/хоног хүчин чадалтай ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэгчээр

“хүрд” ххк шалгарч барилга угсралтын ажил эхлэх зөвшөөрлөө авч ажиллаж байна. “цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ” төслийн төсөвт өртөг:8.5 тэрбум төгрөг бөгөөд уг ажил нь 2021 оны 10 сард дуусах юм.

Баруун-Урт суманд хэрэгжиж буй 5,5 км цэвэр ус, 2,0км ариутгах татуургын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажил үргэлжлүүлэн гүйцэтгэхээр “альянс тех” ххк холбогдох бичиг баримтаа ирүүлээд байна. Гүйцэтгэгч байгууллагын бичиг баримтын бүрдлийг шалгаж дутуу ирүүлсэн бичиг баримтыг гүйцээн авсаны үндсэн дээр ажил үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгоно.

Барилгын хөгжлийн төвөөс эрхлэн гаргадаг барилгын мэдээлэл сэтгүүлд тус аймгийн 2020 оны нэгдүгээр улиралд ашиглалтанд орсон 3 барилгын мэдээллийг хүргүүлж хэвлүүлэхээр боллоо.

Барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг болон материал бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгж ард иргэдэд зориулсан барилгын материалын түүхий эдийн стандартын шаардлага гарын авлага, холбогдох материалын талаарх эхийг бэлтгэн танилцуулж ажиллалаа.

Газрын кадастрын мэдээллийн сангийн веб хувилбарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан нийт 19 өргөдөл бүртгэгдсэн. Үүнд худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах 9 өргөдөл, шинээр газар эзэмших 4 өргөдөл, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 2 өргөдөл, газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах 1 өргөдөл, гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа газар өмчилж авах 1, газар эзэмшил /ашиглалтын газрын зориулалт өөрчлүүлэх 1, газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх 1 өргөдөл тус тус хүлээн авч шийдвэрлээд байна.

Энэ сард аймгийн засаг даргын 13 удаагийн захирамжаар 15 өргөдөл шийдвэрлэгдсэнийг газрын кадастрын мэдээллийн санд захирамжийг бүртгэсэн. Газар эзэмших эрхийн гэрчилгээг 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан.

Газрын кадастрын мэдээллийн сангаас 28 иргэн аж ахуй нэгж, байгууллагад кадастрын үнэт цаасан дээр 84ш хувь баталгаажсан кадастрын зураглалаар үйлчилсэн.

ГЗБГЗГазрын газар зохион байгуулалтын хэлтэстэй хамтран сумдын газрын даамлуудад газар зохион байгуулалтын, Геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны 40 дүгээр тушаалаар батлагдсан "газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ын талаар онлайн сургалтыг зохион байгуулсан. Мөн тус журмын дагуу баруун-урт сумын 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбаруудыг цахим системд бүртгэн оруулж байна. Одоогоор 180 нэгж талбаруудыг оруулаад байна.

Сумдын газрын даамлуудад 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбаруудыг цахим системд оруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна.

2020 онд Баруун-Урт суманд дуудлага худалдаагаар худалдах газруудын хэмжилт тодруулалтыг хийж кадастрын мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. Ланд менежер программын веб хувилбар дээр урьд оны өргүй газрын төлбөрийн нэхэмжлэхийг үүсгэж татварын цахим систем рүү илгээв.

Мал аж ахуйн чиглэлээр: 3 сарын 25-ны байдлаар 1.722.759 эх мал төллөхөөс 145077 эх мал буюу 8.4 хувь нь төллөж гарсан төлийн 99% нь бойжиж байгаа бөгөөд том малын зүй бус хорогдол 11851 байгаа нь нийт мал сүргийн 0.31 хувийг эзэлж байна.

3-р сарын 18-22-ны өдрүүдэд Баяндэлгэр сумын Дэлгэр, Дөхөм багуудад ажиллаж “Баяндэлгэрийн улаан” үүлдрийн 160 ямааны биеийн үндсэн хэмжээ, ноолуурын дээжийг авч маазах-нд хүргүүлээ.

“Мал аж ахуйн өнөөгийн байдал, малын ашиг шимийг сайжруулах нь” сэдэвт телевизийн хэлэлцүүлэгт ХХААГ-ыг төлөөлөл оролцсон.

Улс, аймаг сумын аварга малчдаас аймгийн засаг даргын бнхау-д 2000 хонь хандивлах уриалгыг дэмжиж одоогоор 835 хонь хандивлаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гаргах худгийн захиалгын саналыг хүнс, хөдөө аж ахуйн газраас авч, техникийн тодорхойлолтыг боловсруулж байна.

Хүнс, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, газар тариалангийн чиглэлээр: аймгийн жишсэн дундаж хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, нийтийн хоолны салбарын хүнсний нөөцийн судалгааг сумдаар нэгтгэн гаргаж ххаахүя-нд

хүргүүлсэн ба 7 хоногийн 3 дах өдөр сумдын хүнсний дэлгүүр, худалдааны төв, мал, мах бэлтгэн нийлүүлэгч нараас хүнсний бүтээгдэхүүний хангамж, нөөц, түүхий эдийн нөөц талаарх мэдээг ххаахүя-ны хүбхзг болон аймгийн шуурхай штабт мэдээлж байна.

Ххааг-аас ажлын хэсэг томилж жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд мониторинг хийлээ. Энэ хүрээнд баруун-урт сумын “Оранж бейкери”, “Оргих” цэвэр усны үйлдвэр, “Чамбай фейшн” оёдол, тавилгын цех, иргэн б.октябрийн мод модон эдлэл үйлдвэрлэлийн чиглэлээр авсан хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилтэд хяналт мониторинг хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2020 оны хаврын тариалалтанд шаардагдах үрийн улаан буудайн захиалгыг одоогийн байдлаар Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Мөнххаан сумдын 6 аж ахуй нэгжээс авч нэгтгэн хөдөө аж ахуйг дэмжих санд хүргүүлсэн. Эдгээр аж ахуйн нэгжүүд нь 2700 га талбайд улаанбуудай тариалахаар мэдээ ирүүлсэн.

Хаадсангаас 2020 онд хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэгдэх техникийн мэдээллийг сумдад хүргүүлсэн.

Монгол улсын засгийн газрын санаачилгаар азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” тт-9751 мон төслийн хүрээнд зүүн бүсийн бизнесийн тэргүүлэх чиглэлийг тогтоох зорилго бүхий судалгааны ажлыг энэ сард эхлүүлээд байна. Тус судалгаанд сүхбаатар аймгийн 370 аж ахуй нэгж, 320 өрх хамрагдах бөгөөд судалгааны ажил 80 хувийн явцтай үргэлжилж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/236, А/210-р захирамжаар 18 аж ахуй нэгжийн архи согтууруулах ундаа борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаатай сунгасан.

Коронавирусийн халдвар (covid-19)-ийн тохиолдол монгол улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн засаг даргын 2020 оны А204-р захирамжаар архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 11-16-ны өдөр хүртэл түр хориглосон ба уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилээгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгжийн судалгааг авч тус салбарыг хөгжүүлэх орон нутгийн дэд хөтөлбөрийг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Түмэнцогт, Баяндэлгэр сумдад галзуу өвчин оношлогдож сумдын засаг даргын захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоож мал сүрэгт нь эрүүл мэндийн үзлэг хийж, өвчилсөн болон контакт авсан мал амьтныг зориудаар устгалд оруулж булж устган халдваргүйтгэл хийсэн. Мээг-т хүсэлт тавьсаны дагуу урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын 10 л вакциныг татан авч голомтын бүс нутгийн мал сүрэгт тариад байна.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим гэрчилгээгээр 20 бичиг шивэгдэж мал амьтан, малын гаралтай бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөн хийгдээд байна.

Цахим гэрчилгээгээр бичигдсэн-501, үүнээс: баталгаажсан-486, татгалзсан-15, саатуулагдсан-3, замын постонд шалгагдсан- 106.

- Отор нүүдлийн зориулалтаар- 96 гэрчилгээ
- Үйлдвэр, худалдааны зориулалтаар – 205 гэрчилгээ
- Үржлийн зориулалтаар – 109 гэрчилгээ
- Хүнсний зориулалтаар – 36 гэрчилгээ шивэгдэж ороод байна.

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт байрлах “Ундром” хүнс барааны бөөний худалдааны төв, нисэх буудал, эрүүл мэндийн газар, баруун-урт сумын эдтг-ын удирдлагаас мал эмнэлгийн газарт хүсэлт ирсэний дагуу ажлын хэсэг гарч албан байгууллага, аж ахуй нэгжийн объект, айл өрхийн хашаа хороо, нийтийн эзэмшлийн талбай, хашаа хороо, худаг уст цэг, хүүр сэг зэм, бэлчээрийн нийт 2.681.800 м2 талбайд халдваргүйтгэл хийгдээд байна.

Уул уурхайн чиглэлээр: Засгийн газрын 2019 оны 320 дугаар тогтоолоор улсын хэмжээнд 2019 оны байдлаар олгогдсон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн олголт, бүрдүүлсэн материал, тэдгээрийн үндэслэл, тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн явц байдалд хяналт шалгалт хийж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг тус аймагт 03 дугаар сарын 20-22-ны хооронд ажилласан. Энэхүү хяналт шалгалтын ажлын хүрээнд аймаг, орон нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн

байгууллагуудаас холбогдох материал, мэдээллийг тухай бүр өгч, орон нутгийн саналыг ажлын хэсэгт уламжиллаа.

Бичигтийн боомтоор уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт гүйцэтгэхээр хүсэлт ирүүлсэн “Хөөт транс”, “Тэвш транс” ххк-уудтай тээвэрлэлтийн гэрээ байгуулан холбогдох зөвлөмж чиглэлийг өгсөн.

Улсын онцгой комиссын шийдвэрээр бичигт боомтын үйл ажиллагааг эхлүүлэн бнхау руу уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааг ариутгал, халдваргүйжүүлэлтийн түр дэглэм мөрдөж явуулах бэлтгэл ажлын хүрээнд аймгийн онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудаас тусгай зөвшөөрөл эзэмшигч 8 аж ахуй нэгж, тээвэрлэлт гүйцэтгэх 5 аж ахуй нэгжид ариутгал, халдваргүйтгэлийн журмыг мөрдөх, стандартын дагуу ариутгалын пункт барих, шаардлагатай тоног төхөөрөмж бэлтгэн ажиллах талаар холбогдох үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Мөн аймгийн удирдлагаас дээрх ажлын хүрээнд авто замын шалган нэвтрүүлэх боомтын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний маршрут чиглэлийн дагуу 27 ширхэг авто замын стандарт тэмдэг, тэмдэглэгээ суурилуулах хөрөнгийг шийдвэрлэсэн ба аймгийн цагдаагийн газар уг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 3 аж ахуй нэгжийн өргөдөлд санал авах асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлээ.

Зам тээврийн чиглэлээр: баруун-урт сумын 3-р багт баригдах 1,1 км хатуу хучилттай авто зам барих техникийн тодорхойлолт, зураг төсөл, тоо хэмжээг баталгаажуулан орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Баруун-урт сумын 3-р баг хөл бөмбөгийн талбайн гаднах зам талбай, авто зогсоол барих ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулан батлуулсан.

Улсын онцгой комиссын шийдвэр, мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн засаг даргын 2020 оны а/212 дугаар захирамжаар “коронавируст халдвар /сovid-19/-ын үед орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэх тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх түр журам”-ыг баталж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 48 дугаар тушаалаар байгуулагдсан агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн засаг даргын 2020 оны а/172 дугаар захирамжаар дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулан, салбар зөвлөлийг хуралдуулж, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

03 дугаар сард 227 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан бөгөөд үүнээс стандартын шаардлага хангаагүй буюу тэнцээгүй 18 тээврийн хэрэгсэл байна.

Зорчигч тээвэр: улаанбаатар хотоос сүхбаатар аймаг чиглэлд 47 автобусаар 1217 зорчигч, сүхбаатар аймгаас улаанбаатар хот чиглэлд 44 автобусаар 822 зорчигч зорчсон байна.

Эрчим хүчний чиглэлээр: Сүхбаатар аймгийн төвийн 10/0.4кв-ын хаалттай дэд станцуудын трансформаторын өрөөнд хаалт хашилт хийсэн.

Аймгийн төвийн 0.4кв-ын хэрэглэгчдийн шит тоноглолд үзлэг хийж шаардлагатай засваруудыг хийсэн байна.

Өндөрхаан 110кв-ын ЦДАШ, Асгат, Эрдэнэцагаан, Уулбаян сумын 35кв-ын цдаш, мөнххаан, бүрэнцогтын 15кв-ын цдаш, Түвшинширээ, Сүхбаатар сумын 10кв-ын ЦДАШ-д трассын дагуу үзлэг шалгалт хийж засварын ажлын эзэлхүүн гаргалаа.

35/10кв-ын Уулбаян дэд станцын реле хамгаалалтын туршилт тохируулга хийсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: боажг-аас орон нутгийн онцлогийг харуулахуйц, төрөл бүрийн материал ашиглаж, загвар, хийц, донжийг нь тааруулан урласан, дотоодын болон дэлхийн зах зээлд борлуулж болохуйц брэнд бүтээгдэхүүн бий болгож, орон нутгийн гар урлал, бэлэг дурсгалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйл ажиллгаагаа тасралтгүй явуулах боломжоор хангах зорилгоор “сүхбаатар аймгийн бэлэг дурсгалын шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах уралдаан”-ыг боловсрол соёл урлагийн газар, стандарчилал хэмжил зүйн газар, худалдаа аж үйлдвэрийн танхим,

баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, дарьганга арт зэрэг тбб –уудтай хамтран зарлаад байна.

Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж байгаа аанб-иудтай хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл солилцохоор “мод үржүүлэх, ойжуулах” ААН-үүдийн цахим хуудас үүсгэж ажиллаж байна. Цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч сургалт семинар зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан мэдээлэлээ цахим хэлбэрээр явуулж байна.

Жил бүрийн 3 дугаар сарын 21-ны өдөр тохиодог “дэлхийн ойн өдөр”-ийн хүрээнд боажя-наас зохион байгуулсан цахим хичээлүүдийг судлаж, аан-үүдийн групп бүлгэмд монгол орны ой, ой ба биологийн олон янз байдал, “ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад олон нийтийн оролцоо”, хотын ногоон байгууламжийн асуудал ба шийдэл сэдвүүдийг байршуулж салбарын ажилтнуудад хүргэсэн.

Баруун-урт сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх хүрээнд тарьсан модны арчилгааны ажлыг 50.0 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын тендерийг зарлахаар үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна.

Аанб-уудад тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх чиглэлээр “мод үржүүлэх аргууд” зөвлөмжийг хүргүүлсэн. Өнөөгийн байдлаар улиас бургасны 4000 ш мөчрийг бэлтгээд байна.

Зургаа. Бусад салбарт хийгдсэн ажил

Мэргэжлийн хяналтын газар: Хорио цээрийн үед орон нутгийн эмнэлгийн зохион байгуулалтыг чангатгах, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрт оношлуурын ажилд холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах, эмч ажилчдын сургалт, онол практикийн дадлага зохион байгуулах ажлын хүрээнд: халдварт өртөх эрсдэлээс сэргийлж ххх өмсөж, тайлах дадлага сургуулилтад 13 тасгийн нийт 191 хүн хамрагдлаа. Үүнд эмч-31, сувилагч-107, лаборант-12, үйлчлэгч- 24, жолооч-4, тогооч-8, сантехникч-2, хог хаягдлын ажилтан-1, жижүүр-2 тус тус хамрагдсан байна. Шуурхай хариу арга хэмжээний 3 багийн 18 эмч, эмнэлгийн ажилтанд болон аймгийн нэгдсэн эмнэлгийн 52 их эмчид хувийн хамгаалах хувцас хэрэгслийн талаар сургалт зохион байгуулсан.

Аймгийн боловсрол соёл урлагийн газартай хамтран арилжааны телевизүүдээр цахим хэлбэрээр заагдаж байгаа хичээл, сургалтад хүүхдүүд хэрхэн хамрагдаж байгаа талаар анги удирдсан багш нараар тандалт хийлгүүлж, хичээлийн агуулга, багшийн арга барил, хүүхдэд хүрч байгаа хэлбэр, мэргэжил арга зүйд хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн хэмжээний хүнсний нөөцийн судалгааг нэгтгэн гаргаж мхег-т хүргүүлсэн. Сар шинийн баяраас хойш борлуулагдаагүй, нөөц хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хугацаа, чанарын байдалд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийгдэж 6 газар хамрагдаж, хаяг шошгын зөрчилтэй хадгалалтын хугацаа дууссан 11 нэр төрлийн 64 ширхэг, 3,8 кг 435790 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураан авлаа.

Бичигт автозамын шалган нэвтрүүлэх хилийн боомтоор 2020.02.12-ны өдрөөс эхлэн зорчигч, тээврийн хэрэгсэл нэвтрээгүй, далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн импортлогдоогүй байна.

Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс нь улс, аймгийн Онцгой комисс, Бичигт боомтын зөвлөлийн өргөтгөсөн хурлаас гарсан шийдвэрийн дагуу бичигт хилийн боомтод тээврийн хэрэгслийн ариутгал халдваргүйтгэлийн пункт барих, шаардлагатай тоног төхөөрөмж, ариутгалын бодисоор хангах ажлыг Петрочайна Дачин Тамсаг ххк-д хариуцуулан, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Боомтын орох чиглэлд хилийн шалган нэвтрүүлэх нэгдүгээр хаалтаас урагш 200 метр орчимд байрлах тээврийн хэрэгслийн ариутгал халдваргүйжүүлэлтийн түр пунктийн үйл ажиллагаатай танилцах ажлаар Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэг Бичигт боомтод ажиллаад холбогдох үүрэг чиглэлийг өгсөн ба хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулан ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны 17/102 тоот албан бичгээр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа банкны салбаруудад атм бэлэн мөнгөний машин болон түц машин байршуулсан өрөө тасалгааг байнга ариутгах, үйлчлүүлэгч гар тогтмол гараа ариутгах нөхцлийг бүрлүүлэх талаар үүрэг чиглэл өгч, зөвлөмж хүргүүлээ.

Коронавирусын халдвар монголд илэрсэнтэй холбогдуулан үүсч болзошгүй эрсдэл болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох үнэлгээ"-г мэргэжлийн хяналтын газрын дотоод болон гадаад эрсдэлүүдийг тооцож, хяналтын чиглэл тус бүрээр гарган мэргэжлийн хяналтын ерөнхий газарт цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Мэргэжлийн хяналтын газар нь өндөржүүлсэн бэлэн байдлын үед тусгай горимоор 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа бөгөөд аймгийн шуурхай штаб, баруун, зүүн пост, бичигт боомт, байгууллага дээр хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж, хяналт тавин ажиллаж байна. Мөн баруун-урт-улаанбаатар чиглэлийн нийтийн тээврийн автобусанд өдөр бүр хяналт тавьж, зорчигчдын халууныг хэмжиж, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаж байна.

Стандарт хэмжил зүйн хэлтэс: Баталгаажуулалтын зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулж тохирлын гэрчилгээ хэрэглэх 15 аж ахуй нэгж байгууллагатай тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээг байгуулан ажилласан байна.

Стандартчилал, тохирлын үнэлгээний талаар:Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тохирлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт, Засгын газрын 291-р тогтоол, Стандартчилал хэмжилзүйн газрын тогтоол, журам, дүрэм, Аймгийн засаг даргын захирамж, Хэлтсийн даргын үүрэг даалгавар зэргийг хэрэгжүүлэх үүднээс эхний улирлын байдлаар 20 гаруй аж ахуй нэгжийн худалдаа үйлчилгээний газар тохирлын үнэлгээнд хамрагдсанаас: хүнсний дэлгүүр-5, минимаркет-11, Зоогийн газар- 1, паб караоке-1, тус тус тохирлын гэрчилгээ олголоо.

Хэмжилзүйн талаар: Тайлант хугацаанд иргэн аж ахуй нэгж байгууллагаас өдөр тутам ирэх хэмжих хэрэгсэл баталгаажуулах, шалгалт тохируулга хийлгэх санал хүсэлтийг хүлээн авч барагдуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд электрон болон механик жин- 13, цусны даралтын аппарат-1, цахилгаан тоолуур-2 , лабораторийн жин-0, тус тус баталгаажуулалт, шалгалт тохируулганд хамруулан ажилласан байна.

Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил

Асгат:

Монгол улсын Ерөнхийлөгчийн уриалгыг дэмжиж улсын аварга, хошой аварга, аймаг, сумын аварга малчид болон айл өрхүүдээс 175 хонь хандивласаныг батламжилж, аймгийн засаг даргад батламжийг гардуулан өглөө.

Байгаль орчин: сумын засаг даргын 2020 оны а/20 дугаар захирамжийн хүрээнд нийтийг цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, сумын төвийн ойр орчим, зам дагуух хог, малын хүүр сэг зэмийг цэвэрлэж хаясан. Нийт 8 тн хогийг цуглуулж хогийн нэгдсэн цэгт булж устгасаны зэрэгцээ албан газрын бохирын 15 цэг, малын хашаа хороо 10-ыг ариутгаж халдваргүйжүүлэлт хийлээ.

Боловсрол: сурагчдын теле хичээлд хамрагдалт,эцэг эхэд хүүхдүүдээ тавих хараа хяналт, анхаарал халамж тавих хүүхдээ хичээлээ үзэхэд туслах зэрэг чиглэлийг анги удирдсан багш нараар дамжуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд багш, эцэг эх, сурагчид мэдээллээ солилцож ажиллаж байна. 03 сарын 24-ний байдлаар нийт 242 сурагчдаас 221 сурагч цахим хичээлийг үзэж, судлаж байгаа бөгөөд сурагчдын 91,3% нь хамрагдаж байна.

Баруун-урт:

Байгаль орчин, хог хаягдлын чиглэлээр:хотын төвөөс мал гаргах ажлын хүрээнд малын хашаанд орсон малын мэдээллийг малчдад хүргэж, мэдэгдэх хуудас өгч ажилласан.

Золбин нохой устгалын ажлыг 6 удаа зохион байгуулж, 66 нохой устгасан.

Хогийн нэгдсэн цэгт 2.5 га газарт түрэлт хийж, аюултай хог хаях цэг рүү орох замыг нээсэн. Цас хайлж цасан доорх хог ихээр гарч ирж байгаа тул 1, 3, 5, 9-р багийн хог ачилтын хуваарьт өөрчлөлт оруулж эдгээр багуудын айл өрхийн хог хаягдлыг сард 2 удаа авч ажилласан. Энэ сард нийт 1632 тонн хогийг хогийн нэгдсэн цэгт хүргэсэн. Түүнчлэн нийтийн эзэмшлийн авто зогсоол, явган зам, улсын чанартай авто зам 47,900м², хоёр цэцэрлэгт хүрээлэн 1736м² талбайг цэвэрлэсэн.

Болзошгүй гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах багийг томилгоожуулж төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Нийгмийн хамгааллын чиглэлээр: сумын засаг даргаас тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 өрхийн эрүүл мэндийн төвд 300 ш маск, 900,000 төгрөгийн дэмжлэг үзүүлээ.

Сумын хэмжээнд ажиглалтын байр байгуулах ажлын хэсэг байгуулагдаж “ажиглалтын байрны гэрээ”-г нийт 31 байгууллагын дарга, эрхлэгч засаг дарга байгуулсан. Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг ажиглалтын байрны бэлэн байдлыг хангах чиглэлээр заавар, зөвлөмж өгч ажилласан.

Хөдөө аж ахуй: баруун-урт сумын засаг даргын тамгын газраас коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор халдваргүйжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Нийт 120428 м2 талбайд халдваргүйжүүлэлт хийсэн.

Баяндэлгэр:

Б/ тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Шинэ төрлийн "covid-19" халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд улсын онцгой комиссоос гаргасан уриалгыг дэмжиж аж ахуй нэгж, байгууллага болон иргэдээс “сумын онцгой комисс”-т хандив тусламж үзүүлсэнийг жагсаавал:

- Дөхөм багийн улсын хошой аварга малчин с. Өлзийбаатар, улсын аварга малчин т. Гансүх нар тус тус 50 хонь 1.0 сая төгрөг
- Сумын здтгазрын хамт олон - 100 ширхэг маск, 50 ширхэг гар ариутгалын бодис болон 700 000 төгрөг
- Хүүхдийн цэцэрлэг- 15 кг чацаргана, гар ариутгагч санитол 5 литр, спирт 5 литр, 100 ширхэг маск, 550 ширхэг сурталчилгааны материал, мөн сумын эрүүл мэндийн төвд 160.000 төгрөг, 130.000 төгрөгийн үнэ бүхий хүнсний материал
- Сумын соёлын төвийн хамт олон- 1 өдрийн цалин, 100 ширхэг маск
- Хаан банкны хамт олон- 1,5 литр санитол 3 ширхэг, 15 ширхэг маск
- Ебсургууль-хүн бүр 3 маск, 2000 төгрөгийн аяныг өрнүүлж сумын *эмтөвд* 215 ширхэг маск, 158500 төгрөг, зорилтот бүлгийн 6 өрхийн 24 гишүүн тус бүрт маск, цагдаагийн тасагт маск, 15000 төгрөг

Дархан бадрах өргөө” ххк – 500,000 төгрөгийг тус тус хандивлав.

Эрүүл мэндийн төв: эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй иргэдэд covid-19 халдвараас сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг тогтмол өгч, 390 үйлчлүүлэгчид 4 төрлийн зөвлөмж тараав.

“эмнэлэг бол эрсдэлтэй орчин” шаардлагагүй тохиолдолд эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхгүй байх утсаар холбогдож зөвлөгөө авах уриалгыг гаргаж аж ахуй нэгж, албан байгууллага нийт 18 газар байршуулав.

Соёлын төв: аймгийн онцгой комисст ажилчид тус бүр 5000 төгрөг, хийт 40,000 төгрөгийг, сумын онцгой комисст өөрсдийн оёсон 100 ширхэг маск, нэг өдрийн цалинг хандивлсан.

Номын сан нь 165 иргэнд, 190 номыг гэрээр олгож үйлчиллээ.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: 13 өрхийн 102 ямаанаас ноолуурын дээж авч, 62 эм ямаанд хаврын ангилалт хийсэн байна.

Байгаль орчны чиглэлээр: түүх соёлын дурсгалт зүйлс, экосистем, ландшафт, биологийн төрөл зүйлийн хувьд ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах зорилгоор нөөц газрын аниллаар лүнгийн овоо 54266.175 га, дурсгалт газрын ангиллаар бурхант, өгөөмөр уул 74259.54 га газрыг тус тус тусгай хамгаалалтанд 10 жилийн хугацаатайгаар тусай хэрэгцээний газарт бүртгүүлэв.

Дарьганга:

Нэг. Төрийн удирдлагын чиглэлээр:

-сумын итх-ын тэргүүлэгчдийн хурлаар “дарьганга 100 жил” хөтөлбөрийн төсөл, хариуцан ажиллах комиссыг томилсон шийдвэрийг хэлэлцэв.

-сумын орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хуулийн хүрээнд мөрдүүлэн ажиллах талаар хэлэлцэн шийдвэрлэв.

-коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хандиваар орж ирсэн 2244000 төгрөгийг ариутгал халдваргүйжүүлэлтэд зарцуулах, мал эмнэлгийн байгууллагуудад халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авах, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн

нэгжүүдэд согтууруулах ундаа худалдаалахыг түр хориглох, болзошгүй гамшиг эрсдэл, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий багуудыг тус тус томилон шийдвэр гарган ажиллаж байна.

Хууль эрх зүйн сургалт сурталчилгаа чиглэлээр: сумын онцгой комиссын 23 гишүүнд халдвар хамгааллын хувцас өмсөх, тайлах дадлага, гараа угаах дадлага сургалтыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: 2020.03.16 наас 20 ны өдрүүдэд төсвийн 6 байгууллага тус бүр цар тахлын чиглэлээр болон албан байгууллагынхаа үйлчилгээний чиглэлээр цахим орчинд сурталчилгаа мэдээлэл хийж, лайк, шэйр хийх, мэдээлэл оруулах зэргээр сурталчилгааг хийсэн ба нийт 750 мэдээлэлд 2362 иргэн хандалт хийсэн мэдээтэй байна.

Байгаль орчны чиглэлээр: сумын засаг даргын шийдвэрээр “хоггүй хот айл” шалгаруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Хандив тусламжийн чиглэлээр: сумын онцгой комисст ахмадын хорооноос 2.244,0 мян төгрөг, эмт-өөс 710000 төгрөгийн мөнгөн хандив, бцгхз-наас эмт-д халуун хэмжигч 3 ширхэгийн үнийг, ебс-аас эмт-д 200 ширхэг амны хаалт, цэцэрлэгээс төрийн байгууллагуудад амны хаалт, улавч, витамин зэргийг гардуулсан.

Мөнххаан:

Төрийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: шинэ төрлийн коронавирусын тархалтаас урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах зорилгоор улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт /хэсэгчлэн/ шилжүүлсэнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилласан.

Улсын ок-ийн хөдөлгөөнийг хориглосонтой холбогдуулан хөдөлгөөнт 7 эргүүлийн пост суурин 1 постыг ажиллуулж давхардсан тоогоор 124 албан хаагчдыг дайчлан ажиллуулсан.

Иргэдэд мэдээ мэдээлэлийг сумын цахим 4 групп, сумын вэб сайт 5 багийн засаг дарга нар багуудынхаа цахим хуудас төсөвт 5 байгууллагууд өөр өөрсдийн цахим хуудаст байршуулж мэдээлж ажиллаж байна.

Сумын ок-ын хурлаар covid -19 халдвараас урьдчилан сэргийлэх ажилд иргэд аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудаас өгсөн хандивын мөнгийг здтг-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж захиран зарцуулж байна. Одоогийн байдлаар сумын эмт-д ариутгалын автоклавыг 3600,0 мянган төгрөг, зайнаас халуун хэмжигч 165,0 мян төгрөгөөр сумын онцгой комиссоос хандив болон засаг даргын нөөцөөс шийдвэрлэж өгөөд байна.

Хүүхдийн цэцэрлэг сумын ок-т 10 кг чацаргана, солонгос улсын зайнаас халуун хэмжигч /250,0/ хандивлалаа.

Мөн ахмадын хороо 250,0 мянган төгрөг, нутгийн анар ххк 1,0 сая төгрөг хандивласан. Нийт хандив 3295,0 мянган төгрөг дансанд ороод байна.

Хүнс хөдөө аж ахуй: мөнххаан-улаанбаатар чиглэлийн хатуу хучилттай зам дагуу 30 км-т үхсэн малын сэг зэмийг цуглуулж нэгдсэн хогийн цэгт булж ариутгал халдваргүйтгэлийг хийж ажилласан.

Сумын засаг даргын а/33 дугаар захирамжаар сумын төвд 5 хэсэг 15 хүний бүрэлдхүүнтэй багийг томилгоожуулан айл өрхүүдийн эгнээ хашаа гудамж талбай болон жорлон муу усны цооногт ариутгал халдваргүйтгэл хийж айл өрхүүдэд санамж сэрэмжлүүлэг өгч ойр орчимд хог цэвэрлэгээг хийлгүүлсэн. Нийт 350 айл өрх, 20 малын хашаа саравч, 350 жорлон муу усны цооногт ариутгал халдваргүйтгэлийг ариутгалын бодис хлорын шохой 100кг, суперкилл 25 кг зарцуулж 415000 м/кв талбайд хийсэн.

Сумын төвийн 2 гүн өрмийн худагт картын системд шилжүүлэхтэй холбогдуулан стайл-орд ххк – тай хамтран ажиллах гэрээ хийгээд байна.

Сумын төвийн нохой устгалын ажлыг зохион байгуулж 100 золбин нохой устгасан ба 1.6 сая төгрөгийн зардлыг зд-ын нөөц сангаас гаргасан.

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн чиглэлээр: зорилтот 30 өрхөд коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор маск -60, витамин 100ш сумын ок-оос өгч халдвараас сэргийлэх талаар зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Шинэ ажлын байр 7, ажлын байр зуучлал -7, ажил хайгч 85 бүртгэгдсэн байна.

Сургууль: сургуулийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран сургуульд суралцдаг зорилтот бүлгийн хүүхдүүдэд нийт 6 кг чацаргана 24 ш маск тараасан. Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд нийт 34 бүлгийн 952 сурагчийн эцэг эхээс таны гэр аюулгүй орчин сэдэвтэй асуулга авч нэгтгэн дутагдалтай зүйлд зөвлөмж хүргүүлж ажилласан. Анги удирдсан багш нар сурагчид болон тэдний эцэг эхтэй холбогдон цахим хичээл үзэж буй байдал явцын талаар байнга тайлагнаж байна.

Хүүхдийн цэцэрлэг: хорио цээрийн хугацаанд багш ажилчдын гэрээр ажиллах, ажлын хуваарийг гаргаж, цэцэрлэгийн эрхлэгчийн б\16-р тушаалаар "цахимд ажиллах журам"-ыг боловсруулан баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. \

Эрүүл мэндийн төв: эм эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлсэн. Автоклаб -1, зайнаас халуун хэмжигч-2 ш авсан. Covid – 19 халдвараас урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж зөвөлгөөг эмя болон эмгазар бусад холбогдох газраас мэдээ мэдээлийг авч олшруулан ард иргэдэд цаг тухай бүрт нь хүргэж байна. Мөн эмтөвийн ажилчдад нэг удаагийн хамгаалах хувцас өмсөх тайлах дарааллын талаар дотоодын сургалтыг 2 удаа зохион байгуулж, тусгаарлах өрөөний бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Наран:

Сумын онцгой комиссыг 4 удаа хуралдуулж асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. 3-р сарын 25-ны байдлаар гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 49 хүн, 4 машин, 4.571.600 төгрөгний зардал гараад байна.

Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгавар, болон мэргэжлийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд сумын засаг даргын а/25 дугаар захирамжийг баталж, 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг эхлүүлээд байна. Халдваргүйтгэлийг суманд хүнсний чиглэлээр худалдаа үйлчилгээ эрхлэгч 6-н аж ахуй нэгж, эмийн сан зэрэг хүн олноор үйлчлүүлдэг газруудын орчимд хийж нийт 75 мкв-д ариутгал халдваргүйтгэлийг хийж ажиллалаа.

Боловсрол: “хүүхэд эрхэм хэрэглэгч” үйл ажиллагааг 3 дугаар сарын 15-30-ны хооронд удирдамжийн дагуу зохион байгууллаа. Энэ хүрээнд хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд зориулагдсан бараа үйлчилгээг чанартай болгоход анхаарлаа хандуулж байсан бол энэ жил гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангахад олон нийтийн анхаарлыг хандуулахыг зорьж **миний гэр аюулгүй орчин** сэдэвт судалгаанд бүлгийн эцэг эхчүүдийг идэвхитэй хамруулан ажилласан. Үүнд нийт 89 эцэг эх буюу 79.4% хамрагдсан байна

Эрүүл мэнд: тусгаарлах байр-2 амбулаторын хэсэгт 6 ор дэлгэж, халдвартай, завсрын, эрүүл бүсийг таних тэмдэгжүүлэн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Сүхбаатар:

Аймгийн засаг даргын а/164 дүгээр захирамжийн дагуу сумын засаг даргын а/38 дугаар захирамжийг баталж, болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах багуудыг томилон ажиллуулж байна.

Соёл урлагийн чиглэлээр: жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “ижийдээ захидал бичээрэй” захидлын уралдааныг зохион байгуулж шалгаруулсан. Эхний 3 байранд шалгарсан захидлыг иргэд, олон нийтэд цахим хуудсаар дамжуулан уншиж танилцуулсан.

Түвшинширээ:

Сумын онцгой комисс 03дугаар сард нийт 3 удаа хуралдаж, цаг үеийн байдал болон сумын хэмжээнд хөл хорио тогтоох, сумын шуурхай штаб, хариуцлагатай жижүүр, түр ажиглах байрыг бэлтгэх, хөдөлгөөнт эргүүл пост гаргах ажлын хуваарь зэрэг асуудлаар хэлэлцэж холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Ебсургуулийн дотуур байрыг түр ажиглах байраар бэлтгэж тохижуулах ажлыг зохион байгуулж бэлэн байдалд оруулсан.

Хүүхэд, гэр бүлийн эрсдэлийг тодорхойлох, зураглал гаргах түргэвчилсэн үнэлгээний мэдээллийн санд 540 өрхийн 0-17 насны бүх хүүхдийг хамруулаад байна.

Боловсрол: хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан хүүхдийг хараа хяналттай байлгах, аюулгүй байдлыг хангах, гэрийн нөхцөлд шинэ

коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга замыг сургуулийнхаа түвшинширээ ебс цахим хуудас болон сумын группын хуудсаар дамжуулан эцэг эх асран хамгаалагчдад чиглэл зөвлөмж өгч ажиллаж байна.

Эрүүл мэнд: covid-19 вирус гарч болзошгүй үндсэн дээр эрүүл мэндийн төвөөс комбинзон маск, гутал зэрэг хамгаалах хэрэгсэлүүдийг өөрийн нөөц бололцоогоор авч бэлтгэсэн.

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр: засаг даргын а/26 дугаар захирамжаар “эрчим хүчний тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, бага хүчин чадлын ус халаалтын зуух, цахилгаан байгууламжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагааг хангуулж эрсдэлээс урьдчилан сэргийлэх” ажлын хэсгийг томилж нийт 26 аанэгж, байгууллага хамрагдаж 5 аанэгж цахилгааны засвар хийж, аюулгүй ажиллагааны дүрэм байрлуулж дагаж мөрдөх зөвлөмжүүдийг өгсөн.

Сумын онцгой комиссоос зорилтот бүлгийн 27 өрхийн 98 иргэнд амны хаалт, 43 хүүхдэд витамин өгч дэмжлэг үзүүлсэн.

Монгол улсын тод манлай уяач с.төмөр-очир өөрийн унаган адуун сүргээс хурдан удмын дааганы азтан тодруулах сугалаа явуулж сугалаанаас орсон 3.800.000 төгрөгийг сумын онцгой комисст хандивлахаар шийдвэрлэсэн.

Байгаль орчны чиглэлээр: “ус-дулаан” онөүгазар нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажлыг зохион байгуулж 106 бод, 80 гаруй богыг цуглуулж сэг зэм хаях цэгт төвлөрүүлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийж, сэг зэм хаях цэгийг хаягжуулж ажиллалаа.

Мал эмнэлгийн тасаг: ариутгал халдваргүйжүүлэлт хийх удирдамж гарган хуваарийн дагуу дэлгүүр хоршооны гадна орчин агуулах, олон тооны эрлийз малтай айл өрх, тахианы аж ахуй эрхэлдэг иргэдийн байр, хашаа хороог ариутган халдваргүйжүүлээд байна. Үүнд: зоорь агуулах- 699м² мал амьтны тоног хэрэгсэл-1600м² худаг уст цэг-140м² хашаа хороо-20,0м² бэлчээр-600м² нийтийн эзэмшлийн талбай-570м² нийт-23609м² талбай ариутгаад байна.

Хаатасаг: том малын зүй бус хорогдол 03.25-ны байдлаар 1971, төл бойжилт 15%-тай байна.

Сэг зэм ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэтасагтай хамтран зохион байгуулж 213 бод, 163 бог ариутгаж халдваргүйжүүлсэн. Малчид болон аанэгж, зоорь агуулах, худаг уст цэгийг hісоре, superkill бодисоор 23609 м² талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн байна.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: нийтийн эзэмшлий зам талбайг ногоон байгууламжтай болгох, нөхөн сэргээх зорилгоор “ногоон байгууламж” нийтийг хамарсан ажил, сумын эргэн тойрныг цэвэрлэх зорилгоор “хог цэвэрлэгээ, сэг зэм устгах” нийтийг хамарсан төсөл, бүлгийн зохион байгуулалттай “хүнсний ногоо тарих” бүлгийн төсөл зэргийг бэлтгэн төслийг бэлэн болгосон.

“хамтарсан баг”-ийн хурал хийж сумын төв үйл ажиллагаа явуулж байгаа 14 хүнсний дэлгүүрүүдийн нийгмийн хариуцлагынх нь хүрээнд зорилтот бүлгийн 27 өрхөд коронавирусын эсрэг урьдчилан сэргийлэх зорилгоор дэмжлэг үзүүлэх 10 хоногийн аян зохион байгуулсан. Дэлгүүрүүд 2 ба түүнээс дээш өрх сонгон авч амин дэмтэй хүнсний бүтээгдэхүүн болон ариутгал халдваргүйжүүлэлтийн бүтээгдэхүүн болон урьдчилан сэргийлэх бараа бүтээгдэхүүн өгч дэмжлэг үзүүлж байна. Аяны хэрэгжилт 70 хувьтай явагдаж байна.

Боловсрол: *Нэг багш - Таван маск* аян өрнүүлж 165 маск төвлөрүүлж сумын онцгой комисст 100 маск, 5 кг чацаргана, 1450000 төгрөгийг хандивлалаа. Сумын ажиглалтын байрыг дотуур байранд нээж 8 өрөөг тохижуулан шаардлагатай зүйлсийн жагсаалтыг гарган сумын окомисст өгсөн

Цэцэрлэг: коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн онцгой комиссд 135000 төгрөг, сумын онцгой комиссд 700000 төгрөг, амны хаалт хандивлаж, хөл хорио тогтоосон 10 хоногийн хугацаанд хариуцлагатай жижүүрт гарч буй төрийн албан хаагчдад давхардсан тоогоор 100 хүнд, 20 удаа, 1000000 төгрөгний өртөг бүхий халуун хоол цай хийж сэтгэл санааны болонэд материалын дэмжлэг үзүүлсэн.

Хүүхдүүдийн теле хичээлийн хамрагдалт идэвхи оролцоог сайжруулах үүднээс болзолт уралдаан зарлаж бүлэг тус бүр групптээ уралдаан тэмцээн зарлан теле хичээлийн үр дүнг сайжруулах чиглэлээр эцэг эхтэй хамтарч ажиллаж байна.

Соёлын төв: олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ээжүүд охидыг хамруулан "эндүүрмээр гэнээ би ээжтэйгээ" гэрэл зургийн цахим уралдааныг түмэнцогт соёлын төв цахим группээр зохион явуулж нийт 25 оролцогч, "хулгана жил"-2020 аяны хүрээнд "инээд бол элэгний эм" хөгжилтэй тик ток цахим уралдааныг хөгжилтэй тик ток бичлэгээр 13 оролцогч, хулгана жил -2020 аяны хүрээнд сөб-ын суралцагчдын дунд аман билгийн "ертөнцийн 3-ыг хэн сайн мэдэх вэ" цахим уралдаан, "ээждээ захидал бичээрэй" захидлын уралдааныг насанд хүрэгчид, хүүхэд гэсэн 2 насны ангиллаар зохион байгуулж дүгнэлээ.

Хорио цээрийн дэглэмтэй байгаа үед өөрийн байгууллагын цахим хаягаар монгол ардын үлгэрийг видео хэлбэрт оруулан хүүхэд багачуудад цувралаар хүргэж байна.

Номын сангийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж, энэ сард нийт 127 уншигчдад 153 ш ном, үүнээс насанд хүрэгчдэд 82 иргэнд 21 ш, 53 хүүхдэд 100 ш ном олгож үйлчиллээ.

Түмэнцогт соёлын төвийн нүүр хуудсаар дамжуулан цахимаар уншъя аян зохион байгуулж өгүүллэг, заавал мэддэг байх 10 шүлгийг нийтлэж уншигчдад хүргэж байна.

- "утгын чимэг-2020" цахим яруу найргийн уралдааныг 2020 оны 3-р сарын 23-аас 4 сарын 1 хүртэл зарлаад байна.

Эрүүл мэнд: хүлээлгийн танхимд хөтөч сувилагч ажилуулан нийт 56 үйлчлүүлэгчийн биеийн халууныг хэмжиж амны хаалт зүүхийг зөвлөн короновирусын талаар сургалт сурталчилгаа хийж гарын авлага тараасан байна

Хэвтэн эмчлүүлж буй иргэдийн ар гэрийн эргэлтийг өглөө 07³⁰- 08⁰⁰, орой 20⁰⁰ – 20³⁰ хооронд болгож хязгаарлалаа.

4 ортой, 2 тусгаарлах өрөө бэлдсэн, ор хоорондын зай нь 1 метрээс дээш байршуулсан.

Хариу арга хэмжээний баг томилон төлөвлөгөө гаргаж эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдэд тогтмол дотоодын сургалт хийж бэлэн байдалд бэлтгэж байна. Зайлшгүй шаардлагатай төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж байна

- Комбинзон - 118 ширхэг
- Амны хаалт 1 удаагийн – 550, п95-30, даавуун-380
- Нүүрний хамгаалалт – 60
- Нүдний шил – 20
- Нэг удаагийн халад –70
- Бээлий – 18 хайрцаг
- Гар ариутгагч – 15 литр
- Зайнаас халуун хэмжигч-2
- Улавч-500
- Хүчилтөрөгч өтгөрүүлэгч-1

2009 оны амин чухал эм эмнэлэгийн хэрэгслийн хангамж нь сумын эмнэлэгт байх шаардлагатай 33 нэр төрлөөс 28 төрлийн эм бэлдмэлээр хангагдсан.

Уулбаян:

Боловсрол: монголын харилцаа холбооны зохицуулах хорооноос бсшуся-тай хамтран ебс-ийн сурагчдын дунд зохион байгуулсан “миний гэр-аюулгүй орчин” захидлын уралдаанд 27 сурагч цахимаар оролцлоо. Мөн “хүүхэд хэрэглэгч” аяны хүрээнд google form ашиглаж миний гэр аюулгүй орчин судалгааг 404 эцэг эх асран хамгаалагчаас авсан.

Теле хичээл үзэж буй сурагчдаас 115 сурагч хичээлийн тэмдэглэл, даалгаврын гүйцэтгэлээ багш нартаа илгээж зөвлөгөө зөвлөмж авчээ. Номын богцыг 153 хүүхдэд хүргэн ажиллалаа. Теле хичээлээ хамгийн бүтээлч, идэвхтэй үзэж буй 16 сурагч, түүний эцэг эхэд талархал илэрхийлэн сургуулийн захиргаанаас талархал, дархлааг дэмжих чацаргана хүргүүлсэн.

23 багш 2 сарын хугацаанд 465 теле хичээл үзэж тэмдэглэл хөтлөж, 4 дүгээр улиралд судлах 62 нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулаад байна.

Хүүхдийн цэцэрлэгийн багш нар гэрийн эргэлтийг 2 дах удаа хийж хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн болон цэгээр наадъя, дүрсээр наадъя номнуудыг тараалаа.

“бидний бүтээл” нэртэй багш ажилчид өөрсдийн гараар хийсэн бүтээлийн үзэсгэлэнг гаргалаа. Бүтээлд 16 ширхэг том ном, 8 ширхэг ясан даам, 20 төрлийн үзүүлэн, 538ш тараах материал хийсэн.

Соёл: соёлын биет өв 2, биет бус өв тээгчээр 2 иргэнийг шинээр нэмж бүртгэлээ. Нийтийн номын сан групп нээж “цахим уншлагад нэгдэцгээе” аян зохион байгуулж зохиол бүтээл байршуулж иргэдэд цахим үйлчилгээ үзүүлж байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр: “Төрийн үйлчилгээг малчны хотонд” уриан дор тамгын газраас баг томилон ажиллуулж малчдаас ОНХС-аар хийгдэх ажлуудын санал асуулга авах, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, халамж, нийгмийн даатгалын чиглэлээр мэдээлэл сурталчилгааны ажлыг хийж эхлүүлээд байна.

Архидан согтуурахын эсрэг хийх ухуулга сурталчилгаа тогтмолжиж сарын бүрийн 1,11,21-ний өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдахгүй байх шийдвэрийг гаргаж үүний үр дүнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 60 хувиар буурч нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 23 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Халзан:

Тэргүүлэгчдийн 3 сарын 5-ны өдрийн ээлжит хуралдаанаар сонгуулийн тухай хуулийн дагуу сумын сонгуулийн санал хураах, авах нутаг дэвсгэрийн төвийг тогтоож суманд 3 хэсэг байхаар тэргүүлэгчдийн тогтоол батлагдлаа.

Мал эмнэлэг: Ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хуваарийн дагуу хийж байна. 4-р багийн 56 өрхийн 9400 м² хашаа хороо, 1200 м² өтөг бууц, 56 ш муу усны цооног жорлонгийн 896м² талбайг ариутгаад байна.

Ждүйлдвэр, Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр: 2020 оны 03-р сарын 20-ны байдлаар нийт 18 зээлдэгч байгаагаас 2020 оны 03 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 4 хүнээс 1,207,000 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна. 18 зээлдэгч нартай утсаар ярин эргэн төлөлтөнд төлөх тал дээр анхаарч ажиллаж байна.

Байгаль орчны чиглэлээр: Төрийн байгууллага 3, Төрийн бус байгууллага 3, Аж ахуйн нэгж 4 нийт 10 аж ахуйн нэгж байгууллагын 6438 м² талбайд Жавелины уусмалаар агаарын ариутгал хийсэн. Мөн хашаа 9400 м², Өтөг бууц 1200 м², нүхэн жорлон 56 буюу 896 м² талбайд суперкиллер гэдэг бодисоор ариутгал халдваргүйжилт хийсэн

10 өрхийн 6 тонн хогийг ачиж нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэв Нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулж 5 тонн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэв. Үүнд 5 байгууллагын 65 иргэн хамрагдав

Эрдэнэцагаан:

Ерөнхий боловсролын сургууль: " Хүүхэд эрхэм эрхлэгч " өдрийн хүрээнд 1-5-р ангийн сурагчдын дунд " Миний гэр бүл-миний аз жаргал" гар зургийн уралдаан, 6-12-р ангийн сурагчдын дунд зохион бичлэгийн уралдааныг цахимаар зохион байгуулж байна.

Сургуулийн “Оюунлаг залуус” клубын багш нар санаачлан сумын ОК-д 30ш нөмрөг, 30ш малгай , 4 хайрцаг вакус, 1 хайрцаг бээлийг хүлээлгэн өглөө.

1-5-р ангийн нийт 683 сурагчаас сумын төвд-357, хөдөө-296, бусад-30 теле хичээлээ үзэж байна.6-8-р анги йн нийт 357 сурагчдаас сумын төвд- 188, хөдөө- 156 , бусад аймаг хотод- 13 сурагч хичээлээ үзэж байна.9-12-р ангийн 319 сурагчийн сумын төвд- 171 сурагч, хөдөө- 138 сурагч, бусад аймаг хотод- 10 сурагч теле хичээлээ үзэж байна.

Нийт 1359 сурагчийн 1014 сурагч буюу 74.6 хувьтай теле хичээлээ үзсэн байна.

Эрүүл мэнд: Эх хүүхдэд ээлтэй орон нутаг ажлын хүрээнд ЕБС, Сувд эмийн сан зэрэг байгууллагууд эх хүүхдийн өрөө, живх солих өрөө, хүүхэд саатуулах тоглоомын өрөөнүүдийг тохижуулсан нь бусад байгууллагын хувьд санаа авахуйц ажлын нэг боллоо.

Нярайн эмчилгээний аппарат, шарлалт хэмжигч, ЯТТ, Автоклав, нярайн пульсоксомерт, ургийн зүрхний цохилт хэмжигч зэргийг авахаар ОНХС-аас 12 сая төгрөг

шийдвэрлүүлээд тендэрийн ажил нь явагдаж байна.Эх хүүхдийн өрөөний нэмэлт тохижилтын зардал 1.9 сая төгрөгийг өөрсдийн дотоод нөөцөөс шийдвэрлэж ажилласан. Хүн амд хяналтын үзлэгийн хуваарийн дагуу 3526 хүнд үзлэг хийснээс 1425 урьдчилан сэргийлэх идэвхитэй хяналтаар 425 үзлэг хийж нийт 136 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн байна. Сумын ЭМТ-д 8 эх амаржиж 8 эх хүүхэд энх тунх бойжиж байна. Эмэгтэйчүүдийн үзлэгт нөхөн үржихүйн насны 1720 эмэгтэйн судалгаа гаргаж 266 эмэгтэй хамрагдаж үзлэгийн хувь 15.5хувьтай байна. Үүнээс 96 өвчлөл илэрүүлж 79 эрүүлжүүлж 82.2 хувьтай байна.

Хөдөө аж ахуй: Усгүй бэлчээрийг усжуулах зорилгоор 3 хурдгийн захиалгыг хүргүүлсэн.

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг 4-р багт 5000 га талбайд хийж ажиллахаар төлөвлөөд байна.

2020 оны эхэнд Улсын аварга 1, Аймгийн аварга малчин 5, Сумын аварга малчин 15 болсон амжилттай байна.

Хүн ам зүй нийгмийн хамгаалал: Хүүхэд гэр бүлийн эрсдэлийг тодорхойлж, зураглал гаргах түргэвчилсэн үнэлгээг 0-18 насны хүүхэдтэй 1039 өрхийн мэдээллийг цахимаар шивж 93%-тай оруулав.

Байгаль орчин аялал жуулчлалын хүрээнд: Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг ковшоор түрж цэгцэлсэн. Нийт 6 га талбайд тархсан байсан хогийг 2 га талбай хэмжээтэй болгож багасгаж ажиллалаа.